



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/31/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баянхонгор хот

2023.02.17.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

“Глобаль капитал аудит” ХХК-ын захирал Д.Энхтуяа
Утас: 89499922 Цахим хаяг: enkhtuyad@gmail.com
Аудитор Б.Баасанбат
Утас: 96442101 Цахим хаяг: baasan.bataa@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5.Аудитын илрүүлэлт	19
5.1. Төлбөрийн акт	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/29

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын Цэцэрлэг нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д Орой, эчнээ, албан бус хэлбэрээр иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэсний дагуу Цэцэрлэгийн хувьсах зардлаар тооцсон зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг шинэчлэн баталснаар БШУ-ны сайдын 2022.05.12-ны А/170 тушаалаар "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал"-ыг баталсан байна.

Дээрх өөрчлөлттэй холбоотойгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг санхүүжилтийн эх үүсвэрээс хамааран улсын төсвийн, орон нутгийн төсвийн гэж тайлагнан Сангийн яамны e-balance.mof.gov.mn системд шивж оруулсан байна.

• 005020187

D/2023-A4 Alban toot doc

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>82,175,554.22</u>	<u>104,121,497.89</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	22,056,355.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	22,056,355.00
3121	Төгрөг	00.00	22,056,355.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	22,056,355.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82,175,554.22	82,065,142.89
351	Түүхий эд материал	52,245,598.55	51,776,824.55
35110	Тусгай зориулалттай материал	50,455,598.55	51,776,824.55
35130	Эм боох материал	1,790,000.00	00.00
354	Хангамжийн материал	29,929,955.67	30,288,318.34
35410	Бичиг хэргийн материал	148,300.00	00.00
35420	Аж ахуйн материал	29,524,655.67	28,412,618.34
35440	Түлш, шатах тослох материал	00.00	288,000.00
35460	Хүнсний материал	47,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	210,000.00	1,587,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>605,074,552.73</u>	<u>601,460,305.77</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	605,074,552.73	601,460,305.77
392	Биет хөрөнгө	598,104,552.73	594,490,305.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	621,033,000.00	621,033,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38,047,913.76	-51,898,416.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,819,119.46	44,339,419.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,767,150.28	-22,850,080.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,948,302.00	20,948,302.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,806,073.69	-19,007,187.82
39217	Ном	1,925,269.00	1,925,269.00
393	Биет бус хөрөнгө	6,970,000.00	6,970,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,970,000.00	6,970,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>687,250,106.95</u>	<u>705,581,803.66</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>687,250,106.95</u>	<u>705,581,803.66</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	687,250,106.95	705,581,803.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	219,846,370.54	219,846,370.54
51101	Өмч: - төрийн	219,846,370.54	219,846,370.54
512	Хуримтлагдсан үр дүн	434,612,355.17	452,944,051.88
51210	Өмнөх үеийн үр дүн	434,612,355.17	434,612,355.17
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	18,331,696.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,791,381.24	32,791,381.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>687,250,106.95</u>	<u>705,581,803.66</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	360,095,034.00	470,998,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,627,000.00	16,958,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,627,000.00	16,958,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ	2,650,000.00	15,520,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ	977,000.00	1,438,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	356,468,034.00	454,039,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	329,340,900.00	414,924,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	414,924,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,340,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,504,010.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,504,010.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,623,124.00	39,115,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,623,124.00	39,115,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	366,812,775.92	452,666,703.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	366,812,775.92	452,666,703.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,520,703.92	447,974,745.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,194,275.00	308,709,540.00
210101	Үндсэн цалин	186,684,967.00	225,370,985.00
210102	Нэмэгдэл	27,402,594.00	60,072,555.00
210104	Урамшуулал	24,538,193.00	8,323,892.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,568,521.00	14,942,108.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,458,300.00	38,712,947.00
210201	Тэтгэврийн даатгал	34,074,700.00	26,297,319.00
210202	Тэтгэмжийн даатгал	345,800.00	3,103,906.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	276,800.00	2,483,127.00
210204	Ажилгүйдлийн даатгал	69,200.00	620,783.00
210205	Эрүүл мэндийн даатгал	691,800.00	6,207,812.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,288,074.00	20,637,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,632,074.00	6,361,360.00
210302	Түлш, халаалт	13,656,000.00	14,080,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	196,040.00

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	9,899,057.58	8,610,511.33
210401	Бичиг хэрэг	874,000.00	458,850.00
210402	Тээвэр, шатахуун	1,530,100.00	280,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,416,713.00	00.00
210404	Ном, хэвлэл	18,900.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	209,700.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,037,150.00	3,134,550.00
210408	Бараа материал акталсны зардал	1,812,494.58	4,737,111.33
2105	Нормативт зардал	13,224,700.00	41,625,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,796,300.00	96,700.00
210502	Хоол, хүнс	9,852,900.00	41,529,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	575,500.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	731,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	731,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	140,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,050,800.00	1,506,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	700,800.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,506,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,534,497.34	27,671,596.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	324,000.00	5,570,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	829,000.00	2,966,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,381,497.34	19,134,546.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,292,072.00	4,691,958.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,394,710.00	4,502,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,504,010.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,890,700.00	4,502,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	189,458.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	189,458.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,897,362.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,897,362.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-6,717,741.92	18,331,696.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,558,178.76	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,558,178.76	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,558,178.76	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-9,275,920.68	18,331,696.71

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	356,468,034.00	454,039,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	356,468,034.00	454,039,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	329,340,900.00	414,924,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	414,924,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,340,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,504,010.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,504,010.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,623,124.00	39,115,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,623,124.00	39,115,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	354,108,034.00	431,983,345.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	354,108,034.00	431,983,345.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,555,962.00	427,291,387.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,119,225.00	306,479,887.00
210101	Үндсэн цалин	173,901,600.00	222,681,699.00
210102	Нэмэгдэл	29,192,925.00	60,162,754.00
210104	Урамшуулал	31,957,200.00	8,323,892.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,067,500.00	15,311,542.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,458,300.00	40,942,600.00
210201	Тэтгэврийн даатгал	25,603,900.00	27,888,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,463,600.00	3,263,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,970,900.00	2,610,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	492,700.00	652,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,927,200.00	6,526,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,123,124.00	20,925,400.00
210301	Гэрэл, цахилгаан	4,267,124.00	5,614,360.00
210302	Түлш, халаалт	13,656,000.00	15,115,000.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	196,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,236,813.00	00.00
210401	Бичиг хэрэг	200,600.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,416,713.00	00.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	00.00

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	239,800.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,804,400.00	00.00
2105	Нормативт зардал	15,575,700.00	41,482,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000,300.00	00.00
210502	Хоол, хүнс	9,899,900.00	41,482,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	675,500.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,406,000.00	500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,675,000.00	00.00
210604	Урсгал засвар	731,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	140,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,291,500.00	1,109,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	701,500.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	1,109,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,205,300.00	15,851,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	12,822,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,205,300.00	3,029,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,552,072.00	4,691,958.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,654,710.00	4,502,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,504,010.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,150,700.00	4,502,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	189,458.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	189,458.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,897,362.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,897,362.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,360,000.00	22,056,355.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,360,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,360,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,360,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,360,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,360,000.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	22,056,355.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	22,056,355.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	443,888,275.85	696,526,027.63
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	443,888,275.85	696,526,027.63
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-9,275,920.68	-9,275,920.68
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	434,612,355.17	687,250,106.95
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	434,612,355.17	687,250,106.95
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	434,612,355.17	687,250,106.95
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	18,331,696.71	18,331,696.71
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	452,944,051.88	705,581,803.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	454,039,700.00	431,793,887.00	22,245,813.00	95.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	454,039,700.00	431,792,887.00	22,246,813.00	95.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,039,700.00	431,792,887.00	22,246,813.00	95.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,340,042.00	306,479,887.00	18,860,155.00	94.20
210101	Үндсэн цалин	248,147,700.00	222,681,699.00	25,466,001.00	89.73
210102	Нэмэгдэл	51,721,600.00	60,162,754.00	-8,441,154.00	116.3
210104	Урамшуулал	10,158,200.00	8,323,892.00	1,834,308.00	81.94
210105	Гэрээт ажлын хөлс	15,312,542.00	15,311,542.00	1,000.00	99.99

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,943,500.00	40,942,600.00	900.00	99.99
210201	Тэтгэврийн даатгал	27,841,900.00	27,888,700.00	-46,800.00	100.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,275,400.00	3,263,500.00	11,900.00	99.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,620,300.00	2,610,600.00	9,700.00	99.63
210204	Ажилгүйдлийн даатгал	655,100.00	652,900.00	2,200.00	99.66
210205	Эрүүл мэндийн даатгал	6,550,800.00	6,526,900.00	23,900.00	99.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,113,000.00	20,925,400.00	187,600.00	99.11
210301	Гэрэл, цахилгаан	5,778,700.00	5,614,360.00	164,340.00	97.15
210302	Түлш, халаалт	15,134,300.00	15,115,000.00	19,300.00	99.87
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	196,040.00	3,960.00	98.02
2105	Нормативт зардал	44,675,900.00	41,482,150.00	3,193,750.00	92.85
210502	Хоол, хүнс	44,675,900.00	41,482,150.00	3,193,750.00	92.85
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	0.00	100
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,110,000.00	1,109,700.00	300.00	99.97
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.00	1,109,700.00	300.00	99.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15854800.00	15851650.00	3,150.00	99.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,824,800.00	12,822,400.00	2,400.00	99.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,030,000.00	3,029,250.00	750.00	99.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4502500.00	4502500.00	0.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,502,500.00	4,502,500.00	0.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,502,500.00	4,502,500.00	0.00	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	454,039,700.00	453,850,242.00	189,458.00	99.95
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	414,924,100.00	414,924,100.00	0.00	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	414,924,100.00	414,924,100.00	0.00	100
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,115,600.00	38,926,142.00	189,458.00	99.51
132001	Орон нутгийн төсвөөс	39,115,600.00	38,926,142.00	189,458.00	99.51
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00	0.00	100

620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	0.00	100
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00	0.00	100
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	211.00	151.00	60.00	71.56
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	211.00	151.00	60.00	71.56
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	211.00	151.00	60.00	71.56

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн зорилго, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд зааснаар “бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж зорилго зорилтыг тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар :

- Засгийн газрын 2021.12.21-ны 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар байгуулагдсан
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан хувьсах зардлын дундаж норматив, аргачлал
- БШУ-ны сайдын 2022 оны “Заавар батлах тухай “ А/170 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх заавар аргачлал “
- БШУ-ны сайд, ЭМС-ын 2022 оны А/235, А/340 дугаар хамтарсан “Багшийн эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний тухай тушаал
- Мөн Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2022 оны 107, 192 дугаар тогтоолууд
- БШУ-ны сайдын 2022 оны А/430 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх дүгнэх журам,
- БШУ-ны сайдын 2022 оны А/500 тоот тушаалаар батлагдсан Гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал олгох журам

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Харин Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д зааснаар Цэцэрлэгийн хувьсах зардлаар тооцсон зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайлан БШУЯ-ны БЕГ-т нэгтгэгдэж, орон нутгийн ТЕЗ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдээгүй, Сангийн яамны Э-тайланд хөрөнгө шилжүүлэн тайланг гаргаж, орон нутгийн тайлан эхний үлдэгдэлтэй эцсийн үлдэгдэлгүй, Улсын төсвийн тайланд эцсийн үлдэгдлээр тайланг нэгтгэсэн байна.

Дотоод хяналтыг ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2021 онд боловсруулсан, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 705,581.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 18,331.7 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,175.6	104,121.5	21,945.9

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Мөнгөн хөрөнгө	-	22,056.4	22,056.4
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	82,175.6	82,065.1	(110.4)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	605,074.6	601,460.3	(3,614.2)
Үндсэн хөрөнгө	679,695.7	695,216.0	15,520.3
Хуримтлагдсан элэгдэл	(74,621.1)	(93,755.7)	(19,134.5)
Нийт хөрөнгө	687,250.1	705,581.8	18,331.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	687,250.1	705,581.8	18,331.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	687,250.1	705,581.8	18,331.7

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 22,056.4 мянган төгрөгөөр өссөн Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82,065.1 мянган төгрөг болж 110.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд нийт 68,177.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 1,438.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч 64,988.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 4,737.1 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 695,216.0 мянган төгрөг болж 15,520.3 мянган төгрөгөөр өссөн нь БШУ-ны сайдын 2022.11.23-ны “Журам батлах тухай” А/488 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын салбарын мэдээллийн систем ашиглах, мэдээллийн сан бүрдүүлэх, зохицуулах журам”-ын хүрээнд Боловсролын ерөнхий газраас 2,273.8 мянган төгрөгийн үнэтэй 4 ш зөөврийн компьютер нийлүүлэгдсэн, НҮБ-ийн хүүхдийн сангаас 8,698.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж олгосон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 705,581.8 мянган төгрөг болж 18,331.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын санхүүжилтээр бүрэн санхүүжүүлэхээр нийт зарлагыг 499,860.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, НДШ-ийн зардлыг төлөвлөсөн хэмжээнд нь, урсгал шилжүүлгийн зардлыг 43,161.0 мянган, бусад зардлыг 43,551.3 мянган, нормативт зардлыг 48,056.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 437,279.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативаар тооцож төсвийг хуваарилсан, төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарахад болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжийн зардал, боловсролын байгууллагуудын ажилтнуудад улирал тутам олгодог үр дүнгийн урамшуулал олгох хэлбэр зэрэгт өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Тайлант хугацаанд тус цэцэрлэгийн төсвийн хуваариар улсын төсвөөс авах санхүүжилтийг 414,924.1 мянган, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 39,115.6 мянган төгрөгөөр буюу нийт зарлагыг 454,039.7 мянган төгрөгөөр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхэд 454,039.7 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг бүрэн авсан байна.

Тайлант оны батлагдсан төсөвт 1 удаа өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 431,793.9 мянган төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь тогтмол зардлын санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдлийн 189.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, улсын төсвөөс олгосон санхүүжилтээс 22,056.4 мянган төгрөгийг зарцуулаагүй, мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
ХӨТӨЛБӨР 71801- Сургуулийн өмнөх боловсрол	454,069.7	431,793.9	22,275.8	95.1
АРГА ХЭМЖЭЭ 80112 –Нийтлэг үйлчилгээ	39,115.6	38,926.1	189.5	99.5
АРГА ХЭМЖЭЭ 81605- Эрүүл мэндийг дэмжих	1,500.0	1,498.0	2.00	99.8
АРГА ХЭМЖЭЭ 81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	44,675.9	41,482.1	3,193.8	92.9
АРГА ХЭМЖЭЭ 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,120.4	2,120.0	0.4	100
АРГА ХЭМЖЭЭ 81823- Боловсролын байгууллагын багш,	1,500.0	1,500.0	0.0	100
АРГА ХЭМЖЭЭ 81834- Боловсролын стандарт, сургалт	324,73.4	305,256.0	18,817.4	94.2

АРГА ХЭМДЖЭЭ 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	41,054.4	41,011.6	42.8	99.9
--	----------	----------	------	------

Эх сурвалж: 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Глобал капитал аудит” ХХК-нийн аудитор Д.Энхтуяа, Б.Баасанбат нар 2023 оны 1 дүгээр сарын 25-наас эхлэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хэрэгжүүлсэн.

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн 57 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсөвт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг завсрын аудит хийх явцад анхны батлагдсан төсөвт зардлын 437,279.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,559.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0%-иар тооцон 4,919.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийн хүрээнд 454,069.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас батлагдсан төсвөөс нийт 22,245.8 мянган төгрөгийг хэмнэснээс хуульд хамаарах доорх зардлыг хэмнэж ажиллажээ.

- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын гүйцэтгэлд хяналт тавьж гүйцэтгэлээр санхүүжүүлснээс хоолны зардлаас 3,193.8 мянган төгрөгийн
- Тогтмол зардлаас 189.4 мянган төгрөгийн хэмнэлт гарсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаатай холбоотой 44,675.9 мянган төгрөгийн 1 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 454,377.0 мянган төгрөгийн 21 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 31,358.4 мянган төгрөгийн 5 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 17,096.3 мянган төгрөгийн 7 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийссэн ба завсрын аудитаар 1 ажилтанд амралтын хугацаанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг бүрэн олгосон зөрчил илэрсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 4,117.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 3,589.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 529.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг хугацаанд нь хэрэгжүүлж хэрэгжилтийн тайланг 2022.05.30-ний өдрийн 19 дугаар албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, Fas программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	3,589.4	1	3,589.4	100
Төлбөрийн акт	1	529.7	1	529.7	100
Нийт дүн	2	4,117.3	2	4,117.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн дараагийн аудитаар Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тогтолын 4-т " Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байхыг БСУШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 онд хоолны зардал 3193.8 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй, харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

5.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 386.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоов

5.1. Төлбөрийн акт

1. 2022 оны 6,7-р саруудад ээлжийн амралттай байсан 2 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийн 386,5 мянган төгрөгийг бүтэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэснийг зөрчсөн, санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтан Ш.Энхболдоор илүү олгосон цалин 202.6 мянган, Б.Алтанцоожоор 183.9 мянган , нийт 386.5 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1.2022 оны 6,7-р саруудад ээлжийн амралттай байсан 2 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийн 386,5 мянган төгрөгийг бүтэн олгосон байна.	1	386.5	1	386.5									
ДҮН	1	386.5	1	386.5									

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

17/24425182
Дугаар — БНА-2023/31-НАСТА-ТМЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант 2022 оны 6,7-р саруудад ээлжийн амралттай байсан 2 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийн 386,463.00 төгрөгийг бүтэн ажилласнаар тооцон олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5.бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Илүү тооцож олгосон нийт 386,463.00 /Гурван зуун наян зургаан мянган дөрвөн зуун жаран гурван/ төгрөгийг Цэцэрлэгийн эрхлэгч Б.Цэцгээ, нягтлан бодогч Б.Ганболд нараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх¹

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн эрхлэгч Б.Цэцгээ, нягтлан бодогч Б.Ганболд нарт хариуцуулав²

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Б.МӨНХБАТ

Д.ЦЭЦЭГМАА

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

005050051